

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.09.22

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Холбооны Нөөцийн Сан богино хугацааны хүүгээ есөн сарын дараа анх удаа бууруулсан нь жижиг компаниудын хувьцаанд илүү хүчтэй нөлөө үзүүлээ.
- АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп болон БНХАУ-ын дарга Ши Жиньпин нар утсаар ярьсны дараа Трамп нийгмийн сүлжээнд мэдэгдэл хийхдээ TikTok-ийн АНУ дахь өмчлөлтэй холбоотой тохиролцоонд хүрсэн бөгөөд хоёр орны худалдааны хэлэлцээг урагшлуулах чиглэлээр ахиц гарсныг онцолсон байна.
- ХНС-гийн Эдийн засгийн төсөөллийн тоймд ихэнх бодлого тодорхойлогчид энэ оны эцэс гэхэд нийтдээ 50 суурь нэгжээр хүүг дахин бууруулахаар төлөвлөж буйг харуулсан.
- Хятадын эх газрын хөрөнгийн зах зээл сүүлийн үед өсөлттэй байсан гэхдээ хөрөнгө оруулагчид ашгаа бага багаар хэрэгжүүлж эхэлснээр бага зэргийн уналттай хаагдлаа.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

| | |
|---------------------|--------------|
| Deutsche Bank | 7,000 |
| Société Générale | 6,750 |
| BMO Capital Markets | 6,700 |
| Bank of America | 6,666 |
| Barclays | 6,600 |
| RBC Capital Markets | 6,600 |
| Wells Fargo | 6,500 |
| Citigroup | 6,500 |
| Goldman Sachs | 6,500 |
| Morgan Stanley | 6,500 |
| JPMorgan Chase | 6,500 |
| UBS | 6,400 |
| Дундаж | 6,678 |





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.09.15-09.21

АНУ-ЫН ГОЛЛОХ ХУВЬЦААНЫ ИНДЕКСҮҮД ӨСӨВ

АНУ-ын томоохон хувьцааны индексүүд энэ долоо хоногт түүхэн дээд түвшинд хүрч өсөв. Холбооны Нөөцийн Сан богино хугацааны хүүгээ есөн сарын дараа анх удаа бууруулсан нь жижиг компаниудын хувьцаанд илүү хүчтэй нөлөө үзүүлээ. Russell 2000 индекс 2.16%-иар өссөн байна. Nasdaq Composite 2.21%-иар, S&P 500 индекс 1.22%-иар, Dow Jones Industrial Average 1.05%-иар нэмэгдэв.

ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР БА ТИКТОК-ИЙН ТОХИРОЛЦОО

Өнгөрсөн долоо хоногт худалдааны хэлэлцээртэй холбоотой мэдээлэл их гарсан. Баасан гарагийн өглөө АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп болон БНХАУ-ын дарга Ши Жиньпин нар утсаар ярьсны дараа Трамп нийгмийн сүлжээнд мэдэгдэл хийхдээ TikTok-ийн АНУ дахь өмчлөлтэй холбоотой тохиролцоонд хүрсэн бөгөөд хоёр орны худалдааны хэлэлцээг урагшлуулах чиглэлээр ахиц гарсныг онцолсон байна. Энэ мэдээллээс үүдэн АНУ-ын индексүүд түүхэн оройгоо дахин шинэчлэн тогтоолоо.

ХҮҮ БУУРУУЛЖ, ЦААШДЫН ХҮЛЭЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭВ

Өнгөрсөн долоо хоногийн хамгийн том үйл явдал нь хоёр өдрийн бодлогын хурлын дараа гарсан ХНС-гийн бодлогын хүүгийн шийдвэр байлаа. Хүлээлтэд нийцсэнээр, төв банк бодлогын хүүгээ 25 суурь нэгжээр (0.25 хувь) бууруулсан нь 2024 оны арванхоёрдугаар сараас хойших анхны алхам байв. Шинэ гишүүн Стивен Миран ганцаараа эсрэг санал өгч, 50 суурь нэгжээр (0.5 хувь) бууруулахыг дэмжжээ. Хөдөлмөрийн зах зээлд ажиглагдаж буй сулрал нь энэ шийдвэрийн гол шалтгаан гэж үзсэн бөгөөд бодлогын мэдэгдэлдээ "ажлын байр нэмэгдэх нь саарсан", гэж дурдсан байна. Хүүг бууруулах шийдвэрийн хүлээлт мэдээж өндөр байсан ч түүнээс дутахгүйгээр цаашдын чиг хандлага ямар байх нь хөрөнгө оруулагчдын анхааралын төвд байлаа. ХНС-гийн Эдийн засгийн төсөөллийн тоймд ихэнх бодлого тодорхойлогчид энэ оны эцэс гэхэд нийтдээ 50 суурь нэгжээр хүүг дахин бууруулахаар төлөвлөж буйг харуулсан бөгөөд энэ нь зургаадугаар сард гаргасан төсөөллөөс илүү зөөлөн бодлогын хүлээлт болж байна. 2026–2027 онд ч гэсэн хүү буурах хүлээлт нэмэгдсэн байна.

НАЙМДУГААР САРЫН ЖИЖИГЛЭНГИЙН ХУДАЛДАА ӨСӨВ

АНУ-ын Худалдааны яам наймдугаар сард жижиглэнгийн худалдаа сарын дүнгээр 0.6%-иар өссөнийг мэдээлэв. Энэ нь шинжээчдийн 0.2%-ийн өсөлтийн таамгаас давж, долдугаар сарын (0.6%) өсөлтийн үзүүлэлтийг давтсан. Харин орон сууцны зах зээлийн мэдээллүүд тааруу гарлаа. АНУ-ын Тоо бүртгэлийн товчоо наймдугаар сард орон сууцны барилгын эхлэл өмнөх сараас 8.5%-иар буурч, улирлын тохируулгатай жилийн түвшинд 1.31 саяд хүрсэн нь 1.37 сая гэсэн таамгаас доогуур байв. Үүнээс гадна Үндэсний Барилгачдын Холбоо есдүгээр сарын Орон сууцны зах зээлийн индексээ 32 гэж мэдээлсэн бөгөөд энэ нь наймдугаар сарын түвшинг хадгалагдсан ч шинжээчдийн өсөлтийн хүлээлтэд хүрсэнгүй. Гэсэн хэдий ч ирэх зургаан сарын борлуулалтын хүлээлт өссөн нь моргейжийн хүү буурсан болон ФРС-ийн цаашдын хүү бууруулах хүлээлттэй холбоотой байлаа.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.09.15 – 09.21

БНХАУ-ЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ УНАЛТ ҮЗҮҮЛЭВ

Хятадын эх газрын хөрөнгийн зах зээл сүүлийн үед өсөлттэй байсан гэхдээ хөрөнгө оруулагчид ашгаа бага багаар хэрэгжүүлж эхэлснээр бага зэргийн уналттай хаагдлаа. FactSet-ийн мэдээлснээр, дотоодын CSI 300 индекс 0.44%-иар, Shanghai Composite индекс 1.30%-иар унасан бол Гонконгийн Hang Seng индекс 0.59%-иар өсөв.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД САЙНГҮЙ ГАРЛАА

Хятадын статистикийн товчооны мэдээлснээр, наймдугаар сарын жижиглэнгийн худалдаа жилийн дүнгээр 3.4%-иар өсөж, аж үйлдвэрийн үйлдвэрлэл 5.2%-иар нэмэгдсэн нь энэ оны хувьд хамгийн сул үзүүлэлт боллоо. Bloomberg-ийн мэдээлснээр, хөрөнгийн урсгалын хөрөнгө оруулалтын өсөлт оны эхний найман сарын байдлаар 0.5% болж, цар тахлаас хойш хамгийн бага түвшинд хүрчээ. Эдгээр гурван үзүүлэлт бүгд хүлээлтээс доогуур гарсан бөгөөд эхний хагаст эдийн засаг 5.3%-ийн гайхалтай өсөлт үзүүлсэн ч Хятадын эдийн засаг ерөнхий утгаараа саарч буйг илтгэв. Энэ сулрал эдийн засгийн 5%-ийн өсөлтийн албан ёсны зорилтоо хангахын тулд Бээжин нэмэлт эдийн засгийн тэлэлт (стимул)-ийн бодлого хэрэгжүүлэх магадлал өндөр гэсэн хүлээлт үүслээ. Энэ сарын эхээр Хятад үйлдвэрийн үнийн индекс (factory gate prices) наймдугаар сард тааруу гарч, дараалан 35 дахь сардаа унасан, мөн хэрэглээний үнийн индекс гурван сарын дараа анх удаа сөрөг гарчээ.

ДОТООД ЭРЭЛТ СУЛ, ОРОН СУУЦНЫ ЗАХ ЗЭЭЛ ХҮНД БАЙДАЛД БАЙНА

АНУ-аас ялгаатай нь, Хятад сүүлийн жилүүдэд дефляцитай тэмцэж байна. Гэвч орон сууцны зах зээлийн удаан үргэлжилж буй хямралын дунд дотоодын эрэлт сул хэвээр байгаа нь үнэ урт хугацаанд тогтвортой өсөхөд саад болжээ. Статистикийн товчооны мэдээлснээр, 70 хотын шинэ болон хуучин орон сууцны үнэ наймдугаар сард өмнөх сараас буурсан байна. Мөн China Real Estate Information Corp-ийн мэдээлснээр, Бээжингийн шинэ байрны борлуулалт жилийн дүнгээр 19%-иар унажээ. Эдгээр тоо баримт нь дөрвөн жил гаруйн хугацаанд үргэлжилсэн орон сууцны зах зээлийн доройтол саарах шинж тэмдэг харагдахгүй байгаагийн улмаас, эрх баригчид орон сууцны салбарт чиглэсэн тусгай бодлого хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

| Monday | | Tuesday | | Wednesday | | Thursday | | Friday |
|---|--------------|--------------------------|--------------|--------------------------|----------------------|----------------------------|--|----------------------|
| Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close | Before Open |
| | | FERGUSON | | | | FACTSET | FedEx LENNAR Research Solutions | MoneyHero |
| http://eps.sh/cal | | © 2025 Earnings Whispers | | | | | | |

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

| Monday | | Tuesday | | Wednesday | | Thursday | | Friday |
|---|--------------|--------------------------|---|---|---|--|---|--------------------------------------|
| Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close | Before Open |
| marti | | AutoZone | Micron WORTHINGTON MillerKnoll AYTU Bioscience | CINTAS Uranium Energy Corp | H.B. Fuller STITCH FIX Steelcase | accenture CARMAX BlackBerry JABIL TD SYNTEX LuxExperience | COSTCO WHOLESALE CONCENTRIX LEGACY EDUCATION LightPath | KNOT Offshore Partners LP |
| http://eps.sh/cal | | © 2025 Earnings Whispers | | | | | | |